



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 24 өдөр

Дугаар А/122

Арвайхээр

**Зардал хуваарилах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.б, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны “Эрх шилжүүлэх тухай” 01 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын IV.1.26 дугаарт батлагдсан Багийн төвийн барилга (Өвөрхангай, Баянгол, Богд сум)-д зарцуулах төсөл, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100263

Аймгийн Засаг даргын 2020 оны 03  
дүгээр сарын 04 ны өдрийн 4/120 дугаар  
захирамжийн хавсралт



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН ТӨСВИЙН  
БАГЦАД БАТЛАГДСАН ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД  
ЭРХ ШИЛЖСЭН БАГИЙН ТӨВИЙН БАРИЛГА /ӨВӨРХАНГАЙ,  
БАЯНГОЛ, БОГД СУМ/-ЫН ЗАРДЛЫН ХУВААРИЛАЛТ

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мян төг/
1	Багийн төвийн барилга /Өвөрхангай, Богд сум/	73.000.0
2	Багийн төвийн барилга /Өвөрхангай, Баянгол сум/	67.000.0
	НИЙТ ДҮН	140.000.0

-оОо-